



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 20 өдөр

Дугаар A/160

Арвайхээр

Зардал хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.“а”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны “Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх тухай” А/42 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XV.1.25 дугаарт батлагдсан Худаг /Өвөрхангай/ төсөл, арга хэмжээний 600.000. 000 (зургаан зуун сая) төгрөгийн зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100345

Аймгийн Засаг даргын 2020 оны 04
дугаар сарын 20-ны өдрийн 116 дугаар
захирамжийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 2 ДУГААР
ХАВСРАЛТЫН XV.1.25 ДУГААРТ БАТЛАГДСАН ХУДАГ /ӨВӨРХАНГАЙ/ ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	2020 онд санхүүжүүлэх төсөвт өртөг /мян төг/	2021 онд санхүүжүүлэх төсөвт өртөг /мян төг/
1	Инженерийн хийцтэй гүн өрмийн худаг /Баян-Өндөр, Бүрд, Баянгол, Есөнзүйл, Өлзийт, Сант/	150 000.0	
2	Инженерийн хийцтэй гүн өрмийн худаг /Баруунбаян-Улаан, Богд, Гучин-Ус, Төгрөг, Хайрхандулаан, Нарийнтээл/	150 000.0	
3	Инженерийн хийцтэй гүн өрмийн худаг /Баян-Өндөр, Бүрд, Баянгол, Төгрөг-2, Сант/		150 000.0
4	Инженерийн хийцтэй гүн өрмийн худаг /Баруунбаян-Улаан, Богд-2, Хайрхандулаан, Нарийнтээл, Гучин-Ус/		150 000.0
	НИЙТ ДҮН	300 000.0	300 000.0

-oOo-